ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК

ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ХӨРС, АСЬФАЛТ БЕТОН ХОЛЬЦ БОЛОН БАЛЛАСТЫН ДҮҮРГЭЛТИЙН МАТЕРИАЛЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН АЖИЛ

ТӨСӨВ: 1,609,125,000 төгрөг

Улаанбаатар хот 2026 он

БАТЛАВ.
"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Х.ПҮРЭВЖАРГАЛ

2026 оны 01 дүгээр сарын 20-ний өдөр

ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМЫН ТӨСЛИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ХӨРС, АСЬФАЛТ БЕТОН ХОЛЬЦ БОЛОН БАЛЛАСТЫН ДҮҮРГЭЛТИЙН МАТЕРИАЛЫН ЧАНАРТ ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ДААЛГАВАР

1	Байршил:	Өмнөговь аймгийн Ханбогд сум, Хайрхан багийн нутаг дэвсгэрт хамаарах Гашуунсухайт-Ганцмод боомтод
2	Захиалагч:	"Тавантолгой Төмөр Зам" ХХК
3	Ерөнхий гүйцэтгэгч:	"Хятадын төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп" ХХК
4	Ажлын зорилго	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам төслийн барилга угсралтын явцад материалын туршилт шинжилгээ гүйцэтгэж, ажлын арга зүйн зөвлөмж өгөх, хяналтын баримт бичиг бүрдүүлэх, үнэн зөв хөтлөх, чанарын хяналтыг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх.
5	Ажил хийгдэх газрын хэмжээ:	Төмөр зам 19.455 км Өргөн цариг 8.661 км, *дэлгэмэл урт 12.1 км* Нарийн цариг 10.794 км, *дэлгэмэл урт 20.5 км* Стакадан гүүр 9413.34 у/м Хос замтай 1496 у/м, Өргөн цариг 4256.1 у/м, Нарийн цариг 3660.73 у/м,
6	Үндэслэл:	Гашуунсухайт-Ганцмод боомтын шинээр төмөр зам барьж байгуулах ажлыг чанар стандартад нийцүүлж,техникийн шаардлагын дагуу гүйцэтгэхэд материалын чанарыг хангуулах, гүйцэтгэлийн чанарт үнэлэлт гаргахад тусгай зориулалтын лабораторийн туршилт шинжилгээг гүйцэтгэх шаардлагатай.
7	Ажлын хамрах хүрээ:	Төслийн явцад дараах багц ажилд хэрэглэх Асфальтбетон хольц, Далан,Ухмал,, Балластын дүүргэлтийн материал, түүхий эдийн шинжилгээг тусгай зориулалтын лабораторид хийж, талбайн туршилтыг гүйцэтгэж, холбогдох техникийн шаардлага, стандартад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах; Үүнд: *Багц 1. Төмөр замын дээд доод бүтэц:* *Багц 2. Урт гүүрийн ажил:* *Багц 3. Эрчим хүч:* *Багц 4. Барилга байгууламж:* *Багц 5. Дохиолол холбоо:* *Багц 6. Авто зам:*

		Багц 7. Тоног төхөөрөмж: Жич: Фидик-ийн 2017 он /2022 онд нэмэлт өөрчлөлт орсон Улаан ном/, батлагдсан зураг төсөл, техникийн шаардлага, стандарт, норм, дүрэм технологийн дагуу хийгдэж байгаа эсэхийг магадлах, гарсан доголдолыг засуулах, ажлын гүйцэтгэлийг хянах баталгаажуулах, материалын туршилт шинжилгээтэй холбоотой бүх ажлууд хамаарна.
8	Дагаж мөрдөх хууль эрхзүй,горм дүрэм,стандарт	- Төслийн магадлагдсан зураг төсөл, техникийн шаардлага: - Төмөр замын барилга угсралтын аль нэгэн ажилд мөрдөх үндэсний стандарт шинэчлэгдэн батлагдсан бол хамгийн сүүлийн хувилбарыг зөвшөөрнө: - Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн боловч үндэсний стандарт болж батлагдаагүй стандартуудыг Инженерийн зөвшөөрлөөр мөрдөж болно:
9	Техник хэрэгсэлд тавигдах шаардлага:	- Материалын туршилт шинжилгээнд хэрэглэх лабораторийн багаж, тоног төхөөрөмжүүд болон техник хэрэгслүүд нь MNS ISO/IEC 17025:2018 дугаартай сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлагад нийцсэн, үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангасан иж бүрэн лаборатори, талбайн туршилтыг нэгэн зэрэг гүйцэтгэх багаж тоног төхөөрөмжтэй байх: - Стандартын шаардлага хангасан, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгад хамрагдаж баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрчилгээтэй багаж, тоног төхөөрөмжийг ашиглах:
10	Багийн бүрэлдэхүүн:	- Хөрсний талбайн баг – 2 - Хөрсний лабораторийн баг - 1
11	Хүний нөөц:	Зөвлөх инженер - Авто замын инженер, Барилгын инженер, Барилгын материал үйлдвэрлэлийн технологич инженер, Геоэкологи, Гүүрийн инженерийн аль нэр мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, Мэргэшсэн инженерийн зэрэгтэй, Хяналтын инженерийн буюу түүнээс дээш зэрэгтэй байх. 10-аас дээш ажилласан жилийн туршлагатай. Лабораторийн эрхлэгч - Авто замын инженер, Барилгын инженер, Барилгын материал үйлдвэрлэлийн технологич инженер, Геоэкологи, Гүүрийн инженерийн аль нэр мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, Мэргэшсэн инженерийн зэрэгтэй, Хяналтын инженерийн буюу түүнээс дээш зэрэгтэй байх. 7-аас дээш ажилласан жилийн туршлагатай. Ахлах буюу Ерөнхий инженер - Авто замын инженер, Барилгын инженер, Барилгын материал үйлдвэрлэлийн технологич инженер, Геоэкологи, Гүүрийн инженерийн аль нэр мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, Мэргэшсэн инженерийн зэрэгтэй байх. 6-аас дээш ажилласан жилийн туршлагатай. /Гэрээт байж болно/ Материалын инженер - Барилгын инженер, Барилгын материал үйлдвэрлэлийн технологич инженер, Авто замын инженер, гүүрийн инженерийн аль нэг мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй. 5-аас дээш ажилласан жилийн туршлагатай

		Лаборант буюу Техникч - Барилгын инженер, Барилгын материал үйлдвэрлэлийн технологич инженер, Авто замын инженер, Гүүрийн инженер, МСҮТ төгссөн. Тухайн чиглэлээр 1 буюу түүнээс дээш жил ажилсан.
12	Ажлын даалгавар	Төмөр замын доод, дээд бүтэц, урт гүүр, хоолой, дохиолол холбоо, эрчим хүч, барилга байгууламжийн угсралтын ажилд хэрэглэгдэх материал, түүхий эдийн шинжилгээг холбогдох стандарт, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэж өдөр тутмын хяналтыг тогтмол хийж, ажлын чанарын баталгаажуулалтыг хангана. Мөн зөвлөхийн хяналтын багийг явцын тайлан, үр дүнгийн мэдээллээр шуурхай, бүрэн ханган ажиллана. Үүнд: Материалын гарал үүсэл чанарын баталгаажуулалт - Төмөр замын болон авто замын шороон даланд ашиглах бүх төрлийн эх үүсвэрээс бэлтгэсэн дүүргэлтийн материал техникийн шаардлага хангаж байгаа эсхэд материалын иж бүрэн шинжилгээ хийх. Талбайн хяналт - Стандартчилал хэмжил зүйн газраар баталгаажсан багаж тоног төхөөрөмж ашиглан шороон далан, дүүргэлтийн үеийн ажлын явцад талбайн нягтыг үе тус бүрээр шалгах. - Төмөр замын суурь бүтцийн ус өнгрүүлэх хоолой, гүүр болон хиймэл байгууламжийн хөрс, шороон материалд техникийн шаардлагын дагуу хөрсний стандарт туршилт шинжилгээнүүдийг гүйцэтгэж, шаардлагатай үзүүлэлтүүдийг тодорхойлох, үр дүнг тайлагнах. - Дохиолол холбоо, өндөр хүчдэлийн шон суурилуулах ажлын явцад газар шорооны ажлын талбайн хяналтыг хийж, шаардлагатй туршилт шинжилгээг хийн үр дүнг тайлагнах. - Тоног төхөөрөмж түүний суурилуулалтын ажлын явцад газар шорооны ажлын талбайн хяналт хийх, зайлшгүй хийх шаардлагатай туршилтуудыг стандартын дагуу гүйцэтгэх, үр дүнг тайлагнах. - Дүүргэгч материалын шинжилгээнд хяналт тавих, үр дүнг тайлагнах. - Автозамын далан болон асфальт бетоны ажлын үе шатны ажил тус бүрийн чанарт хяналт тавьж стандарт, норм дүрмийг баримталж байгаа эсэхийг тайлагнах.
13	Баримтлах норм ба дүрэм, стандарт	- Ширхэглэлийн бүрэлдэхүүн MNS AASHTO T-882014 /ASTM D 422:2007 - Уян налархайн үзүүлэлт тодорхойлох лабораторийн арга MNS ASTM D 4318:2006 - Дүүргэгч материалын элэгдэлийн хэмжээг Лос-Анжелсийн багажаар тодохойлох MNS ASTM C 535:2003 - Стандарт бус хүчлэг (2700 кНм/м3)-ээр хөрсний нягтралын үзүүлэлтийг тодорхойлох арга. Хөрсний хуурай үеийн хамгийн их нягт (MDD) болон Чийгийн тохиромжтой хэмжээ MNS ASTM D 1557:2002 - Нягтруулсан талбайн ачаа даацын харьцаа тодорхойлох MNS ASTM D 1883:2002 - Хөрсний чийгийг түргэвчилсэн аргаар тодорхойлох MNS 5284:2003 - Хөрсний хатуулаг (stiffness) ASTM D 1043:2010 - Хөрсний нягтралт ба хувийн жинг элс-конусын аргаар газар дээр тодорхойлох стандарт туршилтын арга MNS ASTM D 1556:2002

		- Хэв гажилтын үзүүлэлтийг хээрийн нөхцөлд тодорхойлох арга (plate bearing test) MNS 2489:1986 - ILAC-MRA олон улсын лабораторийн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллагын үнэлгээг хангасан байх. Итгэмжлэлийн хугацаа төсөл үргэлжлэх хугацаанд хүчин төгөлдөр байх. Итгэмжлэл авсан лабораториторой хамтран ажиллах гэрээ хийсэн байж болно.
14	Удирдлага, зохион байгуулалт	Тусгай зориулалтын хяналтын баг нь Техник технологийн хяналт хэрэгжүүлэгч багын /Инженер/ шууд удирдлага дор ажиллана:
15	Ажил тайлагнахад тавигдах шаардлага	- Стандартын дагуу гүйцэтгэсэн туршилт шинжилгээний үр дүнг баталгаажуулан тухай бүр Инженерт цаасаар болон албан харилцааны цахим хаягаар илгээнэ: - Чанарын хяналтын хүрээнд гүйцэтгэсэн ажлыг сар бүр нэгтгэн, баталгаажуулж Инженерт цаасаар болон албан харилцааны цахим хаягаар илгээнэ:
16	Хөдөлмөрэрүүл аюулгүй байдлыг ханган ажиллах	- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА), эрүүл мэндийн үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөөг баталсан байна; - Гүйцэтгэгч аюултай тохиолдлоос урьдчилан сэргийлэх албан тушаалтанг (ХАБЭА-н ажилтан) төслийн хугацаанд Ажлын талбай дээр томилон ажиллуулах бөгөөд уг ажилтан нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, аюултай тохиолдол (осол, осолд дөхсөн тохиолдол)-оос урьдчилан сэргийлэх, судлан бүртгэх арга хэмжээг хариуцаж ажиллана. (сургалт, зааварчилгаа өгөх) Тухайн ажилтан нь ХАБЭА-н ажилтны сургалтанд хамрагдсан ажил үүргээ биелүүлэх ур чадвартай байна; - Гүйцэтгэгч нь хууль тогтоомжид заасан хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагуудыг дагаж мөрдөх бөгөөд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөл үүсэн гарахаас урьдчилан сэргийлж, ажиллах хүчний аюулгүй ажиллагааг бүрэн хангана; - Ажлын хувцас нэг бүрийн хамгаалах хэрэгсэлийг ажлын талбайд өдөр тогтмол хэрэглэнэ; Талбайд ажиллах тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангасан, таних тэмдэг, өндрийн антен зэргээр тоноглосон байна;
17	Гүйцэтгэх хугацаа	- Гэрээнд заасны дагуу, Захиалагчийн мэдэгдэл хүргүүлэх хүртэл
		-

ХЯНАСАН:
ТХ ХЭЛТСИЙН ДАРГА: Р.ОТГОНСҮРЭН

АХЛАХ ИНЖЕНЕР М.БАТТОГТОХ

БОЛОВСРУУЛСАН:
ТХ ХЭЛТСИЙН МАТЕРИАЛЫН ИНЖЕНЕР: Б.ХОНГОРЗУЛ